Тохиолдол шинжлээрэй.

Тохиолдол №1. Иргэн А, Б нар гар утас худалдах-худалдан авах гэрээ байгуулав. Худалдагч Х нь биет байдлын доголдолтой буюу чанарын шаардлага хангахгүй гар утас Б-д шилжүүлж өгсөн байна.

Тохиолдол №2. "Э"гэгч нь байрныхаа орчимд нохойгоо хошуувч, хүзүүвч, уяагүйгээр зугаалуулдаг байсныг хөршүүд нь байнга сануулдаг байсан боловч тоодоггүй байв. Нэг удаа уг нохой 7 настай "Д" гэдэг хүүхэд рүү дайрсан байна.

Тохиолдол №3. "Б", "Т" нар нэгэн ТҮЦ-ээс ууттай чихэр байсныг аваад зугтсан учир худалдагч нь хойноос нь хөөсөөр "Б"-г нь барьж цагдаад өгсөн. Хэргийг шалгах явцад ууттай чихэр нь 5000 төгрөгийн үнэтэй зөөлөн чихэр байсан бөгөөд тоо ёсоор нь эзэнд нь хүлээлгэн өгсөн байна.

ДАСГАЛ: ГЭМТ ХЭРЭГ МӨН, БИШ.

1.Тохиолдлыг шинжлэн гэмт хэрэг мөн, биш эсэхийг тодорхойлоорой.

2. Дээрх тохиолдол тус бүрийг ямар салбар эрх зүйгээр зохицуулах вэ?

LIVEWORKSHEETS